



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022 оо 28 № 16/2022

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ИХХЭТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНТОГТОХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	52.9	68.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,681.6	1,858.6
	Нийт хөрөнгийн дүн	1,734.5	1,926.8
	Нийт өр төлбөрийн дүн	0.1	0.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,734.4	1,926.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,734.5	1,926.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	655.5	695.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	504.2	494.9
	Үйл ажиллагааны үр дүн	151.3	200.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-12.7	8.1
	Үйл ажиллагааны нийт үр дүн	138.6	192.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	392.7	398.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	383.2	377.7
	Үйл ажиллагааны ЦМГ	9.5	20.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	9.5	20.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542.9	542.9
	Тайлант оны үр дүн	248.8	192.3
	Эцсийн үлдэгдэл	1,734.5	1,926.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	359.6	358.7
	Урсгал зардал	359.6	358.7
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	359.6	358.7
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358.6	357.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1.0	1.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх алба, байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа, Сумын ИТХ-ын тогтоол, Сумын Засаг даргын захирамж, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр сумын нийгэм эдийн засгийн тухайн жилийн зорилтод хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллана.

Эрхэм зорилго: Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зөв бодлого, зөв үйлдэл, зөв манлайллыг түүчээлэгч төрийн байгууллага болно.

Алсын хараа: Ухаалаг төлөвлөлт, оновчтой гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168.5 сая төгрөгийн 13 ажил гүйлгээнээс 137.4 сая төгрөгийн 7, орлогын 43.1 сая төгрөгийн 4 ажил гүйлгээнээс 25.2 сая төгрөгийн 3, хөрөнгө зарцуулах тухай 10 шийдвэрээс 8 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 16.1 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс, 9.1 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1.1 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, 5.0 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Залруулсан алдаа

1. Эд хариуцагч бараа материалын программд эхний үлдэгдэлгүй, тайлант хугацаанд орлого аваагүй фургоны хөшиг нэртэй материалыг хий зарлагдаж, бараа материалын жилийн эцсийн үлдэгдлийн дүнг 7.5 сая төгрөгөөр бууруулж тайлагнасныг залруулж бүртгүүлэв.

2. Цалингаас суутгасан ХХОАТ-ын зардалд 0.04 сая төгрөг илүү шилжүүлснийг авлагаар тусгуулж залруулав.

3. Аймгийн ОНӨГ-ын 2021.11.30-ны өдрийн 268 тоот албан бичигт 44.9 сая төгрөгийн фургон маркийн автомашиныг бүртгэж авах тухай тусгаж хүргүүлсэн байхад тус машиныг 46.5 сая төгрөгөөр буюу 1.6 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулж бүртгүүлэв.

5.2 Акт

1. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын III хавсралтын 2.7 “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэсэн заалтуудыг зөрчиж сумын ЗДТГ-ын даргын 2021 оны А/25 тушаал, сумын Засаг даргын А/129 захирамжаар сахилгын шийтгэл оногдуулсан 2 албан хаагчид нийт 0.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

5.3 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 1.1 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

2. Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168,5 сая төгрөгийн 13 ажил гүйлгээнээс 137,4 сая төгрөгийн 7, орлогын 43,1 сая төгрөгийн 4 ажил гүйлгээнээс 25,2 сая төгрөгийн 3, хөрөнгө зарцуулах тухай 10 шийдвэрээс 8 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

- Мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 1.5 сая төгрөгийн, 4 удаагийн ажил гүйлгээ хийхдээ ажил гүйлгээ гарах тухай бүрд холбогдох журмын дагуу бэлэн мөнгөний тайлан гаргаагүй жилийн эцэст нэг удаа тайлагнасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт заавар”-т тусгагдсаны дагуу бэлэн мөнгөний тайланг НХМаягт МХ-4 маягтаар ажил гүйлгээ хийх тухай бүр гаргаж байх.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Иххэт сумын ЗДТГ нь 2020 онд Квант ХХК-аас үндсэн хөрөнгө худалдан авахаар 3.4 сая төгрөгийг шилжүүлж, нийлүүлсэн хөрөнгө чанарын шаардлага хангаагүйн улмаас нийлүүлэгчид буцаан өгч авлагаар бүртгэн, 2021 онд нийлүүлэгч компани тус авлагыг барагдуулж үндсэн дансанд шилжүүлснийг нэмэлтийн дансанд төвлөрүүлэн хөрөнгө худалдан авсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг байгууллагын үйл ажиллагааны дансаар зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	8	16.1	3	9.1	1	0.9	2	1.1	2	5.0
	НИЙТ	8	16.1	3.	9.1	1	0.9	2	1.1	2	5.0